



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгөөр бий болсон 64,8 тэрбум төгрөгийн өртөгтэй “Эрдэнэт мэдикал” эмнэлгийг хууль бусаар “Медипас” ХХК-д шилжүүлсэн хөрөнгийг төрд хүлээн авч, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад бүртгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Нарангэрэл	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Дэлгэрмаа	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Д.Сувдмаа	Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Р.Ширчинням	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Батболд	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Даваа	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албан тушаалтан
Нарийн бичиг:	Л.Нарантуяа	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлын хэсгийг 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрөөс 27-ны өдрийн хооронд Эрдэнэт хотод томилолтоор ажиллуулсугай.

3. Хөрөнгийг зохих ёсоор хүлээн авч, данс бүртгэлд бүртгэн, тайланг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн дотор танилцуулахыг /Д.Нарангэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003023

ТӨБЗГ тушаал-/2022